

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ЗУРГААДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны хоёрдугаар сарын 12-ны 14 цаг 15 минутад эхэлж, 16 цаг 07 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 58 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|--|--|
| 1 | Өмнөговь аймагт зохион байгуулсан нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай | <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 02 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд Өмнөговь аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Өмнөговь аймагт 2015 оны 02 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 33 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 10 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 3 дугаар</p> |

| | | |
|---|--|--|
| | | <p>хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 7 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 15 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөл /Б.Түвшинбаяр/-д үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 2 | <p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгчээр ажиллаж байсан Э.Мөнхзаяагаас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p> | <p>“Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч тус агентлагийн Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгчээр ажиллаж байсан Э.Мөнхзаяагаас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдлийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн</p> |

| | | |
|---|--|---|
| | | <p>байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ын "Нэг" дэх хэсгийн 3.6- д заасныг удирдлага болгон:</p> <ol style="list-style-type: none"> 1. "Сахилгын шийтгэл ногдуулах тухай" Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 783 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлтэй байна гэсэн, "Шилжүүлэн ажиллуулах тухай" Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 784 дүгээр тушаалыг хууль зүйн үндэслэлгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх. 2. Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай" Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолын "Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны ..., 784 дүгээр тушаалыг хүчингүй болгох эрх зүйн үндэслэлгүй байна" гэж шийдвэрлсэн хэсгийг хүчингүйд тооцох. 3. Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолыг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу биелүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл /Д.Пүрэвдорж/-д үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 3 | <p>Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан Б.Энхтуяагаас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p> | <p>"Ажлаас халах тухай" Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/01 дүгээр захирамжийг эс зөвшөөрч тус сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан Б.Энхтуяагаас Төрийн албаны зөвлөлд</p> |

| | | |
|---|---|---|
| | | <p>гаргасан өргөдлийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 3.4-ын “г, д”- д заасныг удирдлага болгон:</p> <p>1. “Ажлаас халах тухай” Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/01 дүгээр захирамжийг хууль зүйн үндэслэлгүй гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх</p> <p>2. “Ажлаас халах тухай” Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/01 дүгээр захирамжийг хүчингүйд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 4 | Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай | <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 19 төрийн албан хаагчдыг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах:</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр</p> |

| | | |
|---|---|--|
| | | <p>зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх</p> |
| 5 | Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөөс зарим иргэнийг хасах тухай | <p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 151 дүгээр тогтоолын 1 болон 7 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 151 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "9; Татварын хэлтэс; Мэргэжилтэн; Сургалт сурталчилгаа, санхүү, бүртгэл; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Баатарсүх Аззаяа; 67.3", "17; Эрүүл мэндийн газар; Эмнэлгийн тусламжийн хэлтэс; Мэргэжилтэн; Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, эмийн хангамж; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Пүрэвцэнд Даваацэрэн; 61", мөн тогтоолын 7 дугаар хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "5; Татварын хэлтэс; Мэргэжилтэн; Сургалт</p> |

| | | |
|--|--|---|
| | | <p>сурталчилгаа, санхүү, бүртгэл; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Баатарсүх Аззаяа; 67.3", "8; Эрүүл мэндийн газар; Эмнэлгийн тусламжийн хэлтэс; Мэргэжилтэн; Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, эмийн хангамж; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Пүрэвцэнд Даваацэрэн; 61" гэсэн хэсгийг тус тус хасах.</p> <p>2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 88 дугаар тогтоолын 8, 28; 15,35; 16, 36 дугаар хавсралтуудад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 88 дугаар тогтоолын:</p> <ul style="list-style-type: none">• 8 дугаар хавсралтын "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "9; Төмөрбулаг сум; Мал аж ахуй, үржлийн тасаг; Мэргэжилтэн; МЭҮТ-т бэлчээр газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл; Туслах түшмэл ТЗ-3" гэсний "Уртнасан Раднаабазар; 71" мөн тогтоолын 28 дугаар хавсралтын "Туслах түшмэлийн ангиллын төрийн |
|--|--|---|

| | | |
|--|--|---|
| | | <p>жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "4; Төмөрбулаг сум; Мал аж ахуй, үржлийн тасаг; Мэргэжилтэн; МЭҮТ-т бэлчээр газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл; Туслах түшмэл ТЗ-3" гэсний " Уртнасан Раднаабазар; 71"</p> <ul style="list-style-type: none"> • 16 дугаар хавсралтын "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "3; Байгаль орчны газар; Дэлгэрхаан; Байгаль хамгаалагч; Туслах түшмэл ТЗ-2" гэсний "Даваасүрэн Мөнх-Эрдэнэ; 62.6" мөн тогтоолын 36 дугаар хавсралтын "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "3; Байгаль орчны газар; Дэлгэрхаан; Байгаль хамгаалагч; Туслах түшмэл ТЗ-2" гэсний "Даваасүрэн Мөнх-Эрдэнэ; 62.6" • 16 дугаар хавсралтын "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "8; Өмнөдэлгэр; Сумын ЗДТГ; Мэргэжилтэн; Мал аж ахуйн үржил, бүртгэл, мэдээлэл, бэлчээр, усжуулалт хариуцсан; Туслах түшмэл ТЗ-3" гэсний "Сүхбаатар Эрдэнэтуяа; 75.6" мөн тогтоолын 36 дугаар хавсралтын " Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "8; Өмнөдэлгэр; Сумын ЗДТГ; Мэргэжилтэн; Мал аж ахуйн үржил, бүртгэл, мэдээлэл, бэлчээр, усжуулалт хариуцсан; Туслах түшмэл ТЗ-3" гэсний "Сүхбаатар |
|--|--|---|

| | | |
|--|--|--|
| | | <p>Эрдэнэтуяа; 75.6"</p> <ul style="list-style-type: none">• 15 дугаар хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "8; Байгаль орчны газар; Мэргэжилтэн; Мэдээллийн сан хариуцсан; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Цэнд-Арслан Үүрцайх; 75.6" мөн тогтоолын 35 дугаар хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "3; Байгаль орчны газар; Мэргэжилтэн; Мэдээллийн сан хариуцсан; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Цэнд-Арслан Үүрцайх; 75.6" гэсэн хэсгүүдийг тус тус хасах. <p>2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, 2014 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 107 дугаар тогтоолын 1,2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "10; Үндэсний статистикийн хороо; Мэдээлэл боловсруулалт технологийн газар; Шинжээч; Сүлжээ</p> |
|--|--|--|

| | | |
|---|---|---|
| | | <p>техник хангамж; Ахлах түшмэл АА8" гэсний "Мягмаржав Оролзод; 75.33" мөн тогтоолын 2 дугаар хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "3; Үндэсний статистикийн хороо; Мэдээлэл боловсруулалт технологийн газар; Шинжээч; Сүлжээ техник хангамж; Ахлах түшмэл АА8" гэсний "Мягмаржав Оролзод; 75.33" гэсэн хэсгийг тус тус хасах</p> <p>2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 6 | Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүдийн 2014 оны үйл ажиллагааны тайланг үнэлж дүгнэсэн тухай | <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.4, 3.7.1, 3.7.4 Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.1, 5.2, 6.1, 6.2, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 4.5, 4.6, 4.7, 4.11 дэх хэсгийг тус тус баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн 2014 оны үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүнг 1, 2, 3, 4 дүгээр хавсралтаар батлах.</p> <p>2. Салбар зөвлөлүүдээс 2014 оны үйл ажиллагаагаараа тэргүүлсэн Өмнөговь, Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийг сайшааж, Төрийн</p> |

| | | |
|--|--|--|
| | | <p>албаны зөвлөлийн “Батламж” олгож, мөнгөн шагналаар урамшуулах</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагаа нь 2014 онд 60-аас доош хувьтай үнэлэгдсэн Сүхбаатар /56,90%/, Архангай /51,90%/, Говь-Алтай /51,19%/, Баянхонгор /48,57%/ аймаг дахь салбар зөвлөл, Эрүүл мэндийн яам /хуучин нэрээр 50,48%/, Гадаад харилцааны яам /хуучин нэрээр 50,24%/, Төрийн өмчийн хороо /55,24%-ны дэргэдэх салбар зөвлөлүүд үйл ажиллагаагаа эрчимжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж, дүнг 2015 оны 06 дугаар сарын 30-ны дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг нэр дурдагдсан Салбар зөвлөлийн дарга нарт даалгах.</p> <p>4. Салбар зөвлөлүүдийн 2014 оны үйл ажиллагааг дүгнээд, ажил сайжруулах асуудлаар Төрийн албаны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг чиг үүргийн дагуу зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг нийт Салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
|--|--|--|

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ